

**December 25, 1962**

**Memorandum of conversation, Mongolian Prime Minister Yumjaagiin Tsedenbal and Chinese Prime Minister Zhou Enlai**

**Citation:**

"Memorandum of conversation, Mongolian Prime Minister Yumjaagiin Tsedenbal and Chinese Prime Minister Zhou Enlai", December 25, 1962, Wilson Center Digital Archive, Mongolian Foreign Ministry archive: fond 5, dans 1, kh/n 283. Obtained by Sergey Radchenko. <https://wilson-center-digital-archive.dvncitest.com/document/134678>

**Summary:**

General discussion of Sino-Mongolian relations and cultural ties.

**Original Language:**

Mongolian

**Contents:**

Original Scan

2/.

-X-

БИХАУ-ЫН ТӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН ЕРӨНХИЙ САЙД  
НЭЖЭР ЧИСУ ЭНЬ-ЛАЙД БИХАУ-ЫН САЙД НАРЫН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НЭЖЭР ЦЭДЕНБАЛ БАРААЛНА  
САН ТУХАЙ ЯРИАНЫ ТӨМӨРГЛЭЛ

1962 оны 12 дугаар  
сарын 25 -ны өдөр

Бэзжин хот

1962 оны 12-р сарын 25-ны 17 цаг  
30 минутанд Бүх Хятадын Ариун Их Хурлын  
срдонд дарга Цэдэнбал Ерөнхий сайд Чингис  
Эннь-лайд бараалхах үед манай талаас  
байлсан хүмүүс нь Сайд нарын Зөвлөлийн  
орлогч дарга н.Жагварал, Гадаад Явдлын  
Яамны сайд н.Шагдарсурэн, мөн орлогч  
сайд н.Сосорбарам, Өлчин сайд Д.Цэвэгнэц,  
Ардын Их Хурлын депутат С.Батсаа, Гадаад  
Явдлын Яамны 1-р хэлтсийн эрилагч Чимбидорж  
нар байлцав.

Хятадын талаас БИХАУ-ЫН Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Хэ Лун,  
Ли Шян-нянь, мөн орлогч бөгөөд Гадаад  
Явдлын Яамны сайд Чэнь И, Гадаад Явдлын  
Яамны орлогч сайд Цзы Лын-фэй, Гадаад  
Явдлын Яамны Азийн 2-р хэлтсийн дарга  
Чжоу Чю-е нар байлцав.

БИХАУ-ЫН Сайд нарын Зөвлөлийн дарга  
Ю.Цэдэнбал БИХАУ-ЫН Төрийн Зөвлөлийн  
Ерөнхий сайд Чжоу Эннь-лайд нарын ярины  
үндсийг тэмдэглэх нь:

Ю. ЦЭДЕНБАЛ:

Ерөнхий сайд тани урниглаар зочлон ирсн  
завшаанд өөрийн Засгийн Газрын нэрийн  
өмнөөс болон хувиасаа халуун таларилыг  
ерөнхий сайд танд илэрхийлье. Хилийн  
тухай манай хоёр улсын засгийн газрын  
төлөөлөгчдийн ажил амжилттай дуусчээ.  
Ийнхүү хилийн тухай гэрээ байгуулж  
ажлыг бэлтгэжээ. Энэ нь манай хоёр улсын

2.

-8-

ах дуугийн найрамдлыг зузаатгахад ихээхэн ач холбогдолтой үйл явдал боллоо.

**ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:**

Тиймээ. Чухал үйл явдал боллоо гэж бид үзэж байна.

**ЦЭДЭНБАЛ:**

Одоогоос 2 жилийн өмнө Ерөнхий сайд Та манай улсад морилон очиж, найрамдал ба харилцаан туслалцах гэрээ байгуулсан нь их ач холбогдолтой болж билээ. Одоо хилийн тухай байгуулах гэж байгаа гэрээ бол манай хоёр улсын хооронд болон социалист лагерийн найрамдалт харилцаанд чухал ач холбогдолтой зүйл юм.

**ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:**

Намайг 2 жилийн өмнө н.Чэнь И-гийн хэмт Монголд очиход Та нехөд туйлын халуун дотноор хүлээж авсныг бид одоо хүртэл дурсан санаж, талархан ярилцсаар байдаг юм.

**ЦЭДЭНБАЛ:**

Манай их хөрш хятадын ард түмний хувьсгалт тэмцэл ялж, БНХАУ байгуулагдснаас хойш манай хоёр орны найрамдалт харилцаа хөгжих чухал ач холбогдолтой үйл явдуудаар их болов. Энэ нь нийт ард түмний эв найрамдлыг зузаатган бэхжүүлэх хэрэгт тус дэхөм болох ач холбогдолтой хэрэг юм.

Би хувьдаа танай оронд 4 дэх удаагаа зочлон ирж байна. 1952 онд ирээд эдийн засаг, соёлын талаар манай хоёр орон хамтран ажиллах хэлэлцээр байгуулагдсан.

1959 онд Вьетнам зэрэг Азийн орноор аялах замдаа дайрч зочилсон. Дараа нь БНХАУ-ыг тунхагласны 10 жилийн сийн

3.

болов манай нэхдийг Та бүгдээс элэгсэг дотноор угтай авч байгаа явдалд чин сэтгэлийн баяр талархлаа дахин хургэе.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Ийм их үйл явдал болох гэж байгаа үед Таныг өөрийн биеэр зочлон ирж байхад бид заавал халуун дотноор угтах ёстой.

ЦЭДЭНБАЛ:

1959 онд БНХАУ-ын тунхагласны 10 жилийн ойн баярт оролцохдоо танай их хөгжилтэй нилээд тодорхой танилцааж билээ. Түүнээс хойш ч гэсэн шинэ их хөгжлийн өөрчлөлт гарчээ. Энэ нь ёстой Шинь хуа /шинэ хөгжил/ юм.

Манай монгол үгэнд ч шинэ гэдэг үг байдаг юм.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Манай хоёр улс бол айл хөрш орон мөн. Дээр үеэс уламжлалт харилцаатай байсан учраас зарим үг адил байдаг тал бий. Ер нь соёлын талаар харилцаатай улсуудад тийм адил үг зэндээ байдаг.

БНМАУ байгуулагдсанас хойш Зөвлөлт Холбоот Улстай өргөн харилцаатай байсан учраас Зөвлөлтийн туршлагаас суралцах бас танай улс шинэ угсийг хэрэглэх болсон нь Зөвлөлтийн шинжлэх ухаан техникийн одон шинэ үгүүд монгол хэлэнд нэвтэрсан байхаа. Манай Өвөр монголд хуучин бичгээ хэрэглэсээр байгаа юм. Мөн түүнчлэн Өвөр монголд зарим нэр томъёог хятадаас олониг хэрэглэх болжээ. Ар Өвөр монголын хэлэнд харилцан ойлгохгүй зүйл нийээд гарч байгаа байхаа. Монголчууд хэлээ ойлголцоход саад болохоор юмгүй. Манай хуучин бичиг хэдэн

ЦЭДЭНБАЛ:

болов манай нөхдийг Та бүгдээс элэгсэг дотноор угтан авч байгаа явдалд чин сэтгэлийн баяр талархлаа дахин хургэе.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Ийм их үйл явдал болох гэж байгаа үед Таныг өөрийн биеэр зочлон ирж байхад бид заавал халуун дотноор угтах ёстой.

ЦДЭСНВАЛ:

1959 онд БИХАУ-ын тунхагласны 10 жилийн ойн баярт оролцоходо танай их хөгжилтэй нилээд тодорхой танилцах билээ. Түүнээс хойш ч гэсэн шинэ их хөгжлийн өөрчлөлт гарчээ. Энэ нь ёстой Шинь хуа /шинэ хөгжил/ юм.

Манай монгол үгэнд ч шинэ гэдэг уг байдаг юм.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Манай хоёр улс бол айл хөрш орон мөн. Дээр үеэс уламжлалт харилцаатай байсан учраас зарим уг адил байдаг тал бий. Ер нь соёлын талаар харилцаатай улсуудад тийм адил уг зэндээ байдаг.

БИМАУ байгуулагдсанаас хойш Зөвлөлт Холбоот Улстай өргөн харилцаатай байсан учраас Зөвлөлтийн туршлагаас суралцах бас танай улс шинэ үстийг хэрэглэх болсон нь Зөвлөлтийн шинжлэх ухаан техникийн одон шинэ үгүүд монгол хэлэнд нэвтэрсэн байхаа. Манай Өвөр монголд хуучин бичгээ хэрэглэсээр байгаа юм. Мөн түүнчлэн Өвөр монголд зарим нэр томъёог хятадаас олныг хэрэглэх болжээ. Ар Өвөр монголын хэлэнд харилцан ойлгохгүй зүйл нилээд гарч байгаа байхаа. Монголчууд хэлээ ойлготьцод саад болохоор юмгүй. Манай хуучин бичиг хэдэн зуун жилийн боломждоо өөрийн үүргийт гүйцэтгэврийн бичиг. Гавч хуучин бичиг маань

ЦДЭСНВАЛ:

- 8 -

4.

одоогийн хөгжлээс хоногдажээ. Тийм учраас манай улс хуучин үсгийг хамж, шинэ үсгийг хэрэглэх болсон юм.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Шинэ үсгийг хэрэглэсэн боловч монголын хэл хэвээрээ үлдсэн ажээ. Харин агуулгын хувьд зарим шинэ зүйлээр баяжих өөрчлөлт гарсан бизээ.

ЦЭДЭНБАЛ:

Одоо бол коммунизмд шилжин орох замаар хөгжил ахиж байна. Улс түмэн нэг нь нэгээгийн хэлнээс зарим үгийг хэрэглэж хэлээ хөгжүүлэн баяжуулах замаар эцэстээ дэлхий нийтийн нэг хэлтэй болоход ойртох юм.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Аль ч улсын хэлнээс ашигтайг авч коммунизмын үеийн шинэ соёлыг бүрэлдүүлэхэд нилээд удаан хугацаа хэрэгтэй юмдаа. Бид хятадын дөрвөлжин үсгийг латинаар тэмдэглэх бодлоготой. Гэвч энэ бэришээлтэй асуудал юм.

Ю.ЦЭДЭНБАЛ:

Танай төв хэвлэл "Жэнъминъжибао" сонины нэрийн дөрвөлжин үсгийн доогуур латин үсгээр бичжээ.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

"Жэнъминъжибао" гэдэг нэр хэдэн үг болохыг тайлбарлан хэдээд монголоор "Ард түмэн" гэдэг чинь нэг үг үү, хоёр үг үү? гэж асуув.

ЦЭДЭНБАЛ:

"Ард түмэн" гэдэг үг хоёр үг болохыг тайлбарлаж яриад, танай улс ирээдүйд латин үсгийг хэрэглэх үү? гэхэд

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Одоогийн байдлаар латин үсэгт шилжихэд хэдүү байна. Энэ тухай гүйцэд шийдвэрлэсэн зүйлгүй. Судалж боловсруулж байна. Ер нь их хугацаа шаардагдана. Алсдаа чухам ямар амжилт гаргахыг судалж мэдээгүй байна.

- 49 -

5.

Хятадын дөрвөлжин үсгийг дөрвөн улс хэрэглэж байсан юм. Үүнээс Вьетнам латин үсгээр сольсон, Солонгос дөрвөлжин үсгийг нилээд өөрчилж аялгууг тэмдэглэх өвөрмөц үсэгтэй болсон, Япон өвөрмөц үсгээ дөрвөлжин үсэгтэй хольж харэглэсээр байна. Манай хятад латин үсгийг хэрэглэх асуудлыг судлан туршиж байна. Гэвч бид хятад үсгээ орхих гэргүй юм. Хугацаа их хэрэгтэй, латин

үсгийг албадлагаар хэрэглэж болохгүй нь мэдээжийн хэргээ. Ер нь дэлхийн хэлийг нэг ~~бичиж~~ <sup>бичжин</sup> гэхэд хэцүү юм.

Дэлхийн нэг хэлтэй болно гэдэг маань холын ирээдүйн хэрэг юм. Хятад үсэг тэмдгээр бичдэг болохоор аргагүй төвогтэй хэцүү ём даа. Удаан жил замисан энэ үсгийг өөрчлөхэд аргагүй удаан хугацаа хэрэгтэй байхаа.

Тиймээ. Манай үсэг хэдэн мянган жилийн түүхтэй, танай улс шинэ үсэг хэрэглэсний ачаар хүмүүсийг бичигт сургах ба ерөнхий боловсролын хувьд тургэн хөгжиж байгаа бололтой.

Манай хуучин үсэг хөгжлэес хоцрогдсон учир өөрчлөх хэрэгтэй болсон юм. Одоо 8-45 наасны хүмүүс ялангуяа залуу үеийнхэн цөм бичиг мэдиэ. Харин өвгэд хөгжидийн дотор бичиг мэдэхгүй хүмүүс бий. Тэднийг бичигт албадан сургах шаардлагагүй гэж үздэг.


Тиймээ. Танай улсын хүн амыг үндсэндээ бичиг үсэг мэдэх болсон гэж үзэх хэрэгтэй. Манай дөрвөлжин бичигт хэцүү болохоор соёл боловсролын хөгжилд саадтай

Ю. ЦЭДЭНБАЛ:

ЧИОУ ЭНЬ-ЛАЙ:

Ю. ЦЭДЭНБАЛ:

ЧИОУ ЭНЬ-ЛАЙ:



6.

тал байдаг юм. Ялангуяа ерөнхий болого-  
ролын талаар бид бусдаас хожимдож  
явна.

Ю. ЦЭДЭНБАЛ:

Жишээ нь, хоёр мянган жилийн өмнө<sup>1</sup>  
"аяга" гэдэг үгийг тэмдэглэж байсан  
үсэг одоо өөрчлөгдсөн тал бий юу?

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Өөрчлөлт их гарсаан. Тэхдээ зарим юмын  
нэр хуучин тэмдэглэгдсэн хэвээрээ л  
байна.

Ю. ЦЭДЭНБАЛ:

Хятад хэлэнд бичгийн ба ярианы хооронд  
ялгаа хир их вэ?

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Бичгийн ба ярианы хэлний хооронд зөрсө  
багавтар бий. Харин олон муж нутгуудын  
хооронд хэл яриа, аялгууны ялгавар их  
бий. Одоо энгийн ярианы хэлийг бага-  
чууд залуучууд бур ч цэвэр сайнаар ярих  
болж байна. Үүнд Хэбэй мужийн хэлийг  
гол болгоход анхаарч байна.

Ю. ЦЭДЭНБАЛ:

Хятадын муж нутгуудын хооронд харилцаа  
өргөжих, соёл хөгжих нэг хэлэнд нэгдэх  
чиглэлтэй болж байгаа нь ирээдүйд  
дэлхийн соёл улам хөгжих бас л нэг  
хэлтэй болохын тодорхой жишээ болж  
байна. Коммунизм бол эдийн засгийн  
байгуулалтын талаар түргэн бүрэлдэх  
шинжтэй боловч харин дэлхийн нэгдсэн  
соёлын талаар нилээд удах төлөвтэй.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Ер нь соёлын хөгжил бол эдийн засгийн  
хөгжлийн хойноос явдаг химтэй.

Ю. ЦЭДЭНБАЛ:

Улсууд харилцан бие биеэсээ давшилттай  
шинэ зүйл тэргүүний туршлагаас цуцалт-  
гүй суралцах замаар хөгжил ухралтгүй  
явацдах ёстой.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Одоогийн тусгаар тогтносон улс үндэстэн  
өөрсдийн өвөрмөц онцлог байдлаар хөгж-  
лээ ахнулах ёстой. Манай социалист

улсууд харилцан тусдах, хамтран ажиллаж журмыар өөрийнхөө улсын онцлог байдалд тохируулан цааш хөгжих ёстой.

Ю. ЦЭДЭНБАЛ:

Тийм ээ. Тусгаар тогтносон улсууд найрамдлаа улам бэхжүүлж, харилцаагаа сайжруулан энэ үндсэн дээр хөгжлээ тургатгэх ёстой.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Манай хоёр засгийн газрын төлөөлөгчид хилийн асуудлаар хэлэлцээгээ амжилттай хийжээ. Манай Гадаад Явдлын Яамны орлогч сайд тэргүүтэй төлөөлөгчдийг Улаанбаатарт байхад нь Монголын Засгийн Газар, Гадаад Явдлын Яам ажилд нь их тусалсанд талархлаа дахин илэрхийлье.

Ю. ЦЭДЭНБАЛ:

Танай төлөөлөгчид идэвхтэй сайн ажиллаж асуудлыг харилцан ойлгоход дөхөмийг үзүүлсэн билээ. Бас манай төлөөлөгчдийг Бээжинд ажиллахад нь танай Засгийн Газар, Гадаад Явдлын Яам их анхаарал тавьж тусалсан явдалд талархлаа илэрхийлье.

ЧЖОУ ЭНЬ-ЛАЙ:

Танай төлөөлөгчдийг элэгсэг дотноор хүлээн авах нь манай үүрэг юм. Манай төлөөлөгчид Улаанбаатарт 40 шахам хоногсон байхад харин танай төлөөлөгчид манайд ирээд төдий л удаагүй шүү дээ: Нэхэр Цэдэнбал Та манай төлөөлөгчдийг биеэрээ хүлээн авч уулзсан нь тэдний ажилд чухал тусыг хургэжээ.

Ю. ЦЭДЭНБАЛ:

Бид ах дүү хөрш орныхоо төлөөлөгчдийг элэгсэг дотноор хүлээн авч ажилд нь туслах нь манай үүрэг билээ.

Гэх зэргээр харилцан ярилцаж уулзалтыг дуусгав. Нэхэр Чжоу Энъ-лай хамтарч зургаа авахуулахыг урив.